



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/135

Чингис хот

Цэргийн бэлтгэл албаны сургалт  
зохион байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2018 оны н/01 дугаар тушаал, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ийн 2.1.3-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах гэрээний дагуу Цэргийн бэлтгэл албаны 1 дүгээр зэргийн үүрэгтний сургалтыг Зэвсэгт хүчний 327 дугаар ангитай хамтран Биндэр суманд 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулсугай.
2. Сургалтад зарцуулах төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.
3. Сургалтад хамрагдах цэргийн бэлтгэл үүрэгтэн нэг бүрт мэдэгдэх хуудас өгч бүрэн оролцуулахыг Биндэр сумын Засаг даргад, сургалтыг Зэвсэгт хүчний Жанжин штабын Хуурай замын цэргийн командлалаас гаргасан хөтөлбөрийн дагуу сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж дүн, тайланг илтгэхийг Цэргийн штаб /дэд хурандаа Н.Хүрэлээ/-т тус тус үүрэг болгосугай.
4. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Цугларалт, бэлтгэл сургууль, дайчилгаа, түр цэргийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ АЛБАНЫ СУРГАЛТЫН ТӨСВИЙН ТООЦОО

№	Сургалтын төрөл	Орон нутгийн төсөв	БХЯ-ны санхүүжилт	Нийт	Хянасан
1	1 дүгээр зэргийн үүрэгтний сургалт	1000000	2498000	3498000	

ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ АЛБАНЫ СУРГАЛТЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	Өдрийн хоол	Порц	308	6000	1848000	
2	Өглөө, оройны хоол	Порц	28	6000	168000	
3	Талх	ширхэг	504	300	151200	
4	Цай	ширхэг	504	150	75600	
5	Багшийн буудлын зардал	төгрөг	24	10000	240000	
6	Дэвтэр	ширхэг	40	1000	40000	
7	Бал	ширхэг	40	850	34000	
8	Дизель түлш	литр	200	2110	422000	
9	Багшийн урамшуулал	төгрөг	2	150000	300000	
10	Багшийн замын зардал	төгрөг	2	40000	80000	
11	Шагнал	төгрөг	5	15000	75000	
12	Томилолт	төгрөг	4	16000	64000	
	Нийт				<b>3497800</b>	